



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар A/353

Арвайхээр


Хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.a, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Аймаг, сум баяр наадмыг зохион байгуулахгүй байх тухай” А/321 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт /ковид-19/-ын орон нутаг дахь эрсдэлийн түвшин өндөр байгаа тул хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээг аймгийн хэмжээнд зохион байгуулахыг хориглосугай.
2. Онцгой нөхцөл байдлын үед хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахгүй байхыг сумын Засаг дарга нар, аймаг, сумдын морин спорт уяачдын холбоо (Ю.Үнэнбүрэн)-нд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100757